



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦӨГТ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 143

Амардалай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7 дахь заалтууд, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 1 ний өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэл ХХААХҮЯ-ын сайдын 2023 оны A/02 дугаар тушаал, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны A/87 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны A/219 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Урьдчилсан сэргийлэх дархлаажуулалтын ажлын хэсгийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Д.Наранцэцэг (МЭТ-ийн дарга)

Гишүүд: М.Даваацэрэн (Дэлгэрбаяндалай МЭҮН -ийн эмч)
Э.Дэлгэрмаа (Дэлгэрбаяндалай МЭҮН -ийн эмч)
М.Ганьхүү (Арвин тэгш баялаг МЭҮН-ийн эмч)
Н.Балданжав (Арвин тэгш баялаг МЭҮН-ийн эмч)
Б.Довууч (1-р багийн Засаг дарга)
Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга)
Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга)

2. Гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтад мэдрэмтгийн малыг 2023 оны 04 дүгээр сарын 20-ноос 15 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулж ажилсугай.

3. Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилсан сэргийлэх дархлаажуулалтад үхэр сүргийг бүрэн хамруулах, малчид мал бүхий иргэдэд зар мэдээг хүргэж, бэлэн байдлыг хангаж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Дархлаажуулалтад үхрийг бүрэн хамруулж, ажлын хэсгийг мэргэжил арга зүйгээр ханган шуурхай үр дүнтэй зохион байгуулан ажиллахыг ажлын хэсгийн гишүүд, дархлаажуулалтын үйл ажиллагаа, Мал эмнэлгийн нэгдсэн системийн гүйцэтгэлд хяналт тавьж, захирамжийн хэрэгжилтийг тайлагнан ажиллахыг ажлын хэсэг (Д.Наранцэцэг) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Л.ЗОЛЖАРГАЛ

